БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## БАЯННУУР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: БУА-2023/92/НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Булган аймаг<br>2023 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудит ХХК<br>Захирал: М.Буянбулган<br>Утас: 70342580 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


**1.АУДИТЫН ДҮГНЭЛТ** ........ 2

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 4

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 9

- **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа** ........ 9
- **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин** ........ 10
- **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал** ........ 10
- **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд** ........ 11
- **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв** ........ 11

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 12

- **4.1 Ерөнхий зүйл** ........ 12
- **4.2 Материаллаг байдал** ........ 12
- **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 12
- **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 13
- **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 13
- **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 13
- **4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 13
- **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 13

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 13

- **5.1 Төлбөрийн акт** ........ 14
- **5.2 Албан шаардлага** ........ 14
- **5.3 Зөвлөмж** ........ 14

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 14


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТАГ | Төрийн аудитын газар |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |

**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Аялагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 123

танай ______________ -ны № ______________ т

БАЯННУУР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ЦЭРЭНДУЛАМ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 онд Боловсролын салбарт төсвийн шинэчлэл хийгдсэн ба улсын төсвөөс 735,236.7 мянган, орон нутгийн төсвөөс 140,157.3 мянган, нэмэлт санхүүжилтээр 1,220.0 мянган нийт 876,614.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өмнөх оноос 163,902.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Сургуулийн дотуур байрны тохижилт, барилгын зураг төсвийг эцэг эхийн хандив, сургуулийн төсөв, Чулуутын багш ХХК-иар хийлгэсэн. Мөн 2023 оны Орон нутаг хөгжүүлэх сангийн төсөвт дотуур байрны хатуу эдлэл болон гал тогооны агааржуулалт урсгал засварын нийт 33 сая төгрөгийг суулгуулсан.

00S020136

**Аудитын гол асуудал**

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд аймгийн Боловсролын газар болон сумын Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 96 хувийн биелэлтэйгээр тайлагнасныг сумын Засаг дарга 85.5 хувийн биелэлттэйгээр дүгнэсэн.

2022 онд хувь хүнээс 400.0 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **25,290,828.28** | **91,482,596.96** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 51,682,997.68 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 51,682,997.68 |
| **33** | **АВЛАГА** | 0.00 | 400,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 400,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 25,290,828.28 | 39,399,599.28 |
| **351** | **Түүхий эд материал** | 377,200.00 | 0.00 |
| 35130 | Эм боох материал | 377,200.00 | 0.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 24,913,628.28 | 39,399,599.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 523,000.00 | 218,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,045,938.23 | 21,956,729.23 |
| 35460 | Хүнсний материал | 4,344,690.05 | 17,224,570.05 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,361,166,477.81** | **1,294,964,408.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,361,166,477.81 | 1,294,964,408.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,331,012,477.81 | 1,264,810,408.17 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,429,211,567.49 | 1,429,211,567.49 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (191,610,324.26) | (259,541,317.46) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 7,845,000.00 | 7,845,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (3,138,000.00) | (4,707,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 82,304,098.00 | 100,344,660.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (26,385,119.93) | (34,827,858.10) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 43,571,055.50 | 41,641,855.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (20,022,890.33) | (22,145,860.81) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 21,370,140.00 | 21,370,140.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (17,050,396.61) | (18,603,267.65) |
| 39217 | Ном | 4,917,347.95 | 4,222,489.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 30,154,000.00 | 30,154,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,700,000.00 | 1,700,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 28,454,000.00 | 28,454,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,386,457,306.09** | **1,386,447,005.13** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 0.00 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,386,457,306.09** | **1,386,447,005.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,386,457,306.09 | 1,386,447,005.13 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 232,416,592.14 | 232,416,592.14 |
| 51101 | Өмч: - төрийн | 28,454,000.00 | 28,454,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (181,429,415.44) | (181,439,716.40) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (181,429,415.44) | (181,429,415.44) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | (10,300.96) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,335,470,129.39 | 1,335,470,129.39 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,386,457,306.09** | **1,386,447,005.13** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **719,353,144.48** | **891,196,649.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 0.00 | 0.00 |
| **110** | **Орлогын албан татвар** | 0.00 | 0.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,640,505.48** | **14,581,849.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,640,505.48 | 14,581,849.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,640,505.48 | 14,581,849.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 6,640,505.48 | 14,581,849.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **712,712,639.00** | **876,614,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 604,798,500.00 | 875,394,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.00 | 735,236,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 604,798,500.00 | 0.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 0.00 | 140,157,300.00 |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,449,080.00 | 1,220,800.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,449,080.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 1,220,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 106,465,059.00 | 0.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 106,465,059.00 | 0.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **827,446,214.65** | **889,860,210.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **827,446,214.65** | **889,860,210.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 771,799,960.70 | 847,409,629.68 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 455,002,279.36 | 509,739,063.06 |
| 210101 | Үндсэн цалин | 258,219,955.58 | 372,791,379.41 |
| 210102 | Нэмэгдэл | 162,070,871.31 | 105,985,892.70 |
| 210104 | Урамшуулал | 34,711,452.47 | 30,961,790.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,534,300.69 | 66,852,908.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,510,764.05 | 45,364,950.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,972,121.53 | 5,337,047.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,177,696.98 | 3,580,671.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 929,475.66 | 1,940,283.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,944,242.47 | 10,629,956.47 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106,173,959.00 | 107,280,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,449,759.00 | 8,230,925.00 |
| 210302 | Түлш, халаалт | 101,724,200.00 | 99,049,075.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 32,302,886.00 | 0.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 485,480.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,016,214.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 469,000.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,112,400.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,153,392.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,066,400.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 28,759,060.00 | 45,074,710.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 327,340.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,673,770.00 | 45,074,710.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,757,950.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 903,500.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 903,500.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 290,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 290,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 414,150.00 | 3,580,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 414,150.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 3,580,060.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 96,419,825.65 | 113,882,887.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,277,100.00 | 18,521,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,386,700.00 | 5,795,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 80,756,025.65 | 89,565,887.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 55,646,253.95 | 42,450,580.53 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,335,330.00 | 42,450,510.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 17,915,330.00 | 42,450,510.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 420,000.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,310,923.95 | 70.53 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,310,923.95 | 70.53 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(108,093,070.17)** | **1,336,438.79** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 3,457,840.00 | 1,346,739.75 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,457,840.00 | 1,346,739.75 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (3,457,840.00) | (1,346,739.75) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(111,550,910.17)** | **(10,300.96)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **712,712,639.00** | **876,614,800.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | 0.00 | 0.00 |
| **110** | **Орлогын албан татвар** | 0.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **712,712,639.00** | **876,614,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 604,798,500.00 | 875,394,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.00 | 735,236,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 604,798,500.00 | 0.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 0.00 | 140,157,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,449,080.00 | 1,220,800.00 |
| 131103 | **ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө** | 1,449,080.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | **Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого** | 0.00 | 1,220,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 106,465,059.00 | 0.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 106,465,059.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **702,443,639.00** | **812,941,802.32** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **702,443,639.00** | **812,941,802.32** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **649,236,875.05** | **765,419,271.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 447,327,760.52 | 510,139,063.06 |
| 210101 | Үндсэн цалин | 265,811,425.97 | 373,191,379.41 |
| 210102 | Нэмэгдэл | 147,124,693.28 | 105,985,892.70 |
| 210104 | Урамшуулал | 34,391,641.27 | 30,961,790.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,038,719.53 | 66,852,908.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,605,958.23 | 45,364,950.43 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,108,240.20 | 5,337,047.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,286,512.20 | 3,580,670.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 821,727.92 | 1,940,283.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,216,280.98 | 10,629,956.57 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 105,565,559.00 | 107,280,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,449,759.00 | 8,230,925.00 |
| 210302 | Түлш, халаалт | 101,115,800.00 | 99,049,075.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,556,586.00 | 0.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 466,480.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,023,000.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 469,000.00 | 0.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 265,500.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,332,906.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 999,700.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,146,400.00 | 52,882,640.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 429,400.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,295,600.00 | 52,882,640.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,421,400.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 899,500.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 899,500.00 | 1,000,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 290,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 290,000.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 147,150.00 | 3,580,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 147,150.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 3,580,060.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8,265,200.00 | 23,684,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,668,000.00 | 15,636,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,597,200.00 | 8,048,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **53,206,763.95** | **47,522,530.53** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,895,840.00 | 47,522,460.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 15,475,840.00 | 47,522,460.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 420,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 37,310,923.95 | 70.53 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 37,310,923.95 | 70.53 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **10,269,000.00** | **63,672,997.68** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,269,000.00** | **11,990,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,269,000.00 | 11,990,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 10,269,000.00 | 11,990,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(10,269,000.00)** | **(11,990,000.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.00 | 0.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 51,682,997.68 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 51,682,997.68 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **232,416,592.14** | **1,335,470,129.39** | **(181,429,415.44)** | 1,386,457,306.09 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **232,416,592.14** | **1,335,470,129.39** | **(181,429,415.44)** | 1,386,457,306.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **232,416,592.14** | **1,335,470,129.39** | **(181,429,415.44)** | 1,386,457,306.09 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (10,300.96) | (10,300.96) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **232,416,592.14** | **1,335,470,129.39** | **(181,439,716.40)** | 1,386,447,005.13 |

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.0** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **876,614,800.00** | **824,931,802.32** | **94.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **876,614,800.00** | **812,941,802.32** | **92.7** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **829,054,200.00** | **765,419,271.79** | **92.3** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **557,079,200.00** | **510,139,063.06** | **91.6** |
| 210101 | Үндсэн цалин | 422,004,500.00 | 373,191,379.41 | 88.4 |
| 210102 | Нэмэгдэл | 122,006,400.00 | 105,985,892.70 | 86.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 13,068,300.00 | 30,961,790.95 | 236.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **68,497,300.00** | **66,852,908.73** | **97.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,000,000.00 | 45,364,950.43 | 98.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,411,700.00 | 5,337,047.00 | 98.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,329,400.00 | 3,580,670.94 | 82.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,932,700.00 | 1,940,283.79 | 100.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,823,500.00 | 10,629,956.57 | 98.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **107,280,000.00** | **107,280,000.00** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,500,000.00 | 8,230,925.00 | 149.7 |
| 210302 | Түлш, халаалт | 101,680,000.00 | 99,049,075.00 | 97.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 100,000.00 | 0.00 | 0.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **52,889,200.00** | **52,882,640.00** | **100.0** |
| 210502 | Хоол, хүнс | 52,889,200.00 | 52,882,640.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,000,000.00** | **1,000,000.00** | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,000,000.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **6,586,300.00** | **3,580,060.00** | **54.4** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,365,500.00 | 3,580,060.00 | 66.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **35,722,200.00** | **23,684,600.00** | **66.3** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,674,000.00 | 15,636,400.00 | 56.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,048,200.00 | 8,048,200.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,560,600.00** | **47,522,530.53** | **99.9** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 47,560,600.00 | 47,522,460.00 | 99.9 |
| 213403 | Төвлөрүүлэн шижүүлэх | 0.00 | 70.53 | 0.0 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **11,990,000.00** | 0.0 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 0.00 | 11,990,000.00 | 0.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **0.00** | **876,614,800.00** | **0.0** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **0.00** | **735,236,700.00** | **0.0** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 0.00 | 735,236,700.00 | 0.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **0.00** | **140,157,300.00** | **0.0** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 0.00 | 140,157,300.00 | 0.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **0.00** | **1,220,800.00** | **0.0** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 1,220,800.00 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.0** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.00** | **51,682,997.68** | **0.0** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль 2022 оны Боловсролын салбарын төсвийн шинэчлэл хүрээнд улсын төсвөөс 735,236.7 мянган, орон нутгийн төсвөөс 140,157.3 мянган, нэмэлт санхүүжилтээр 1,220.0 мянган нийт 876,614.8 мянган төгрөгийн санхүүжилт авч өнгөрсөн оноос 163,902.1 мянган төгрөгөөр өссөн.

Сургуулийн дотуур байрны тохижилт, барилгын зураг төсвийг Чулуутын багш ХХК-иар хийлгэсэн. Мөн 2023 оны Орон нутаг хөгжүүлэх сангийн төсөвт дотуур байрны хатуу эдлэл болон гал тогооны агааржуулалт урсгал засварын нийт 33 сая төгрөгийг суулгуулсан.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2022 онд аймгийн Боловсролын газар болон сумын Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 96 хувийн биелэлтэйгээр тайлагнасныг сумын Засаг дарга 85.5 хувийн биелэлттэйгээр дүгнэсэн. 2022 онд хувь хүнд 400.0 мянган төгрөгийн урьдчилгаа өгч авлага үүсгэсэн.

## 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай";
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай";
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол "Автомашин ашиглалтын тухай";
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт "Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам";
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай",
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Боловсролын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. 2021оны 01-р сарын 22-ний А/05 тушаалаар байгуулсан Өмч хамгаалах зөвлөлийг ажлуулдаг. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

## 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг Си Ти Эс програм хангамж ашигладаг.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.3 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* 3

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 51,683.0 | 51,683.0 |
| Авлага | 0.0 | 400.0 | 400.0 |
| Бараа материал | 25,290.8 | 39,399.6 | 14,108.8 |
| Үндсэн хөрөнгө | 1,361,166.5 | 1,294,964.4 | -66,202.1 |
| **Нийт хөрөнгө** | **1,386,457.3** | **1,386,447.0** | **-10.3** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 1,386,457.3 | 1,386,447.0 | **-10.3** |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,386,457.3** | **1,386,447.0** | **-10.3** |

Хүснэгтээс харахад 2022 онд өмнөх оны үзүүлэлтээс салбарын бодлогын шинэчлэлтэй холбоотой мөнгөн хөрөнгө 51,683.0 мянган, худалдан авсан хүнсний барааны үлдэгдэл, хандиваар ирсэн мал зэрэг нь бараа материалыг 14,108.8 мянган төгрөгөөр өсгөхөд, машин тоног төхөөрөмжөөс 753,8 мянган, тавилга эд хогшлоос 718,5 мянган, номын фондоос 1,254.4 мянган нийт 2,726.7 мянган төгрөгийн хөрөнгө актласан, тайлант онд 89,947.3 мянган төгрөгийн элэгдэл тооцогдсон нь үндсэн хөрөнгө буурахад нөлөөлсөн байна. Шинээр ажиллагчидтай холбоотой 400.0 мянган төгрөгийн авлага үүссэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төслөө санхүүжүүлэлтийн эх үүсвэрийг улсын төсвөөс нийт зарлагыг 969.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсийг 92.8 сая төгрөгөөр бууруулж 876.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн баталсан төсөвт өөрчлөлт ороогүй ба гүйцэтгэл 94.1 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант нэмэлт төсөв аваагүй..

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөлүүдийг тусгасан болно.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023  оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган нар хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн  нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн төсвийн нийт зардлын суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 876,614.8  мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,149,2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

`Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан   хуулиар хориглосон  зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил  46,940.1 мянган, НДШ-ийг  1,644.4 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйчилгээний зардлыг 3,006.2 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 12,037.6 мянган нийт 63,628.3 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 онд нийт 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа болоогүй 2, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн тухай 16 тушаал мэдээллэхээс 3-ыг  орхигдуулсан байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10 цагаас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээлэлтэй танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдөр 64 тоотоор төлбөрийн акт, 65 тоотоор албан шаадлагын хариу, 66 тоотоор зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь ТАГ-т хүргүүлжээ.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | **1** | 300,0 | **1** | 300,0 | 100.0 |
| Албан шаардлага | 1 | 230.0 | 1 | 230.0 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | 600.0 | 2 | 600.0 | 100.0 |
| **Нийт дүн** | **4** | **1,130.0** | **4** | **1,130.0** | 100.0 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар өгсөн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилтийг завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 7,320.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 7,320.7 мянган төгрөгийн алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн[2] 2 алдааг дахин давтан гаргахгүй байх албан шаардлага, зөвлөмж тус бүр 1-ийг өглөө.

**5.1 Төлбөрийн акт**

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар 1 албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

**1. Ажил гүйлгээний ангитай холбоотой асуудал**

***Илрүүлэлт:*** 2022 оны жилийн эцсийн бараа материалын үлдэгдлийг тооллогын комиссын бүртгэлээр бус нярвын тайланг баталгаажуулсан баримтаар тайлагнасныг байгууллагын удирдлагуудад танилцуулсан. Байгууллага аудитын шалгалтын хугацаанд комиссын бүрэлдэхүүнийг дахин ажиллуулж зөрчлийг шийдвэрлэсэн. Энэ нь санхүүгийн тайлангийн эдийн засгийн ангилал буруу илэрхийлэгдэх, ТБОНӨТХ-ийн 72 дугаар зүйлийн 4.4-т: Тооллогын комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх;, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т: нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;, 20.2.6-д: эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Эрх зүйн актуудыг мөрдлөг болгож, дотоод хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Залруулга | 1 | 7320.7 | | | 1 | 7320.7 | 1 | 7320.7 | | | 1 | 7320.7 |
| Дүн | 1 | 7320.7 | | | 1 | 7320.7 | 1 | 7320.7 | | | 1 | 7320.7 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл

| | | | | | | | | | | | шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрх зүйн актыг мөрдөөгүй | 2 | 0.0 | | | 1 | 0.0 | 1 | 0.0 | | | | |
| Дүн | 2 | 0.0 | | | 1 | 0.0 | 1 | 0.0 | | | | |